



# ШИНЭ ТӨГСӨГЧИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

ЗАРЛАГДЛАА



“Оюу толгой” ХХК-ний ажиллах хүчний 97-с илүү хувь нь монгол ажилтнууд бөгөөд компанийн стратегийн гол чиглэл нь ажиллагсдынхаа чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд оршдог билээ. Бид өндөр чадвартай боловсон хүчнийг татахыг зорьдог. Ингэснээр бид хамтдаа Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулах, аюулгүй, дэлхийд өрсөлдөхүйц зэсийн үйлдвэрлэлийг бий болгож чадах юм.

Шинэ төгсөгчдийн хөтөлбөр нь шинэхэн төгсөгчдөд ажлын туршлага олгож, тэднийг сорих, хөгжүүлэх, туршлагатай зөвлөхүүдтэй холбож дадлагажуулах замаар үндэсний шилдэг техникийн мэдлэг бүхий боловсон хүчнийг бэлтгэхэд чиглэсэн хөтөлбөр юм.

## Тавигдах шаардлага

- Монгол улсын иргэн байх
- Дотоодын болон гадаадын их, дээд сургуулийг бакалавр болон магистрын зэргээр 2021, 2022, 2023 онд төгссөн байх (2023 онд төгсөх оюутнуудын хувьд сургуулийн тодорхойлолт, эхний хагас жилийн дүнгийн жагсаалт хавсаргах)
- Англи хэлний зохих мэдлэгтэй байх
- Аюулгүй ажиллагааны талаар зохих мэдлэгтэй байх
- Харилцааны өндөр соёлтой, багаар ажиллах чадвартай байх
- Дээрх заасан мэргэжлийн чиглэлээр төгссөн байх
- Өргөдөл гаргагч нь Өмнөговь аймагт оршин суудаг эсвэл ирээдүйд шилжин суурьших боломжтой бол давуу тал болно

## Шинэ төгсөгч хөтөлбөрт

- Коучинг, Менторшип
- Гүйцэтгэлийн удирдлага, үнэлгээ хийх байнгын явц
- Техникийн болон мэргэжлийн өсөлт, хөгжил
- Манлайллын хөгжил
- Рио Тинто компаниас хэрэгжүүлдэг глобал Шинэ төгсөгчийн хөтөлбөрт хамрагдах боломж
- Дэлхийн хэмжээний цахим сургалтын материал болон коучинг систем
- Рио Тинто компанийн бусад салбарын Шинэ төгсөгчидтэй холбогдож, туршлага хуваалцах боломж

➤ **ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА:**  
**2023 оны 4 сарын 17 хүртэл**

Эрдэс баялгаас эрдэм мэдлэг,  
ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ





### СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ:

Анхан шатны шалгаруулалтад тэнцсэн өргөдөл гаргагчдыг сонгон шалгаруулалтад урина Хугацаанаас хоцорсон болон дутуу бүрдүүлсэн материалыг шалгаруулалтад оруулахгүй болохыг анхаарна уу

Шинэ төгсөгчийн албан тушаал	Мэргэжлийн чиглэл	Орон тоо	Анкет бөглөх холбоос
Шинэ төгсөгч – Барилгын инженер	Барилга	2	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч – Цахилгааны инженер	Цахилгаан	2	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч – Механикийн инженер	Механик	4	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч – Хэвлэл мэдээллийн ажилтан	Харилцаа, бизнесийн удирдлага, сэтгүүл зүй	1	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч – Байгаль орчны ажилтан	Байгаль, хүрээлэн буй орчны инженер	1	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч – Мэдээлэл технологийн ажилтан	Мэдээлэл технологи	2	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч – Хаягдлын далангийн инженер	Уул уурхайн инженер	2	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч - Уул уурхайн инженер	Уул уурхайн инженер	6	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч - Өргүүрийн инженер	Механик эсвэл автоматжуулалт	1	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч - Тактикийн үйл ажиллагааны инженер	Уул уурхай, үйлдвэрлэлийн автоматжуулалт, өгөгдлийн шинжээч, мэдээлэл технологи	1	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч - Усан хангамжийн инженер	Ус хангамж, усны инженерчлэл, усны барилгын хангамж	1	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч - Удирдлагын системийн инженер	Уул уурхайн инженер, Автоматжуулалт, процессын удирдлага, цахилгаан болон электроник	1	<a href="#">Энд дарна уу!</a>
Шинэ төгсөгч - Өгөгдлийн боловсруулалтын инженер	Мэдээлэл технологи	1	<a href="#">Энд дарна уу!</a>

